



**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2025 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 01/73

Улаанбаатар хот

Г М.Бат-Амгаланд сахилгын  
шийтгэл ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13, 48 дугаар Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам”-ын 1.3.1, 1.3.3, 6.1, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/1716 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 10.1, 10.9, 10.10.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Майдарын Бат-Амгалан албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ удаа дараа хангалтгүй биелүүлсэн нь дотоод хяналт шалгалт болон өөрийн гаргасан тайлбараар тогтоогдсон түүнд 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөр тасалбар болгон төрийн албанаас халах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. М.Бат-Амгалангийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд нэвтрэх эрхийг цуцлахыг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар (Б.Ариунболд)-т даалгасугай.

3. Төрийн болон албаны нууц задруулахгүй байх баталгаг гаргуулж, холбогдох хууль тогтоомжийг сануулахыг нэгжийн нууц хамгаалах ажилтан (Г.Анхныбаяр)-д үүрэг болгосугай.

4. М.Бат-Амгалангийн ажлыг зохих журмын дагуу хүлээлцэж, 106 дугаартай улсын бүртгэгчийн тэмдгийг хүлээн авч хадгалахыг Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс (Л.Бальдирмаа)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар (Д.Давааням)-т тус тус үүрэг баглосугай.

5. Энэ тушаалыг эс зөвшөөрвөл улсын бүртгэгч М.Бат-Амгаланд тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



У.БОЛДХҮҮ

142500512